



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 282

Улаанбаатар хот

Г
“Атар өргөө” ХК-ийн үнэт цаасны
бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Компанийн тухай хуулийн 32.4, 31.2.1 зүйлийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Атар өргөө” ХК-ийн нэг бүр нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 174,136 /нэг зуун далан дөрвөн мянга зуун гучин зургаа/ ширхэг хувьцааны нэг бүрийн нэрлэсэн үнийг нь 18,000 /арван найман мянга/ төгрөг болгон өөрчилж үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Саруул/, хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандуулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. 2011 оны ногдол ашгийн мөнгөн хөрөнгийг компанийн хувьцаа эзэмшигчдийн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламж дахь дансанд 2012 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн дотор байршуулахыг “Атар-Өргөө” ХК /Ж.Сайнжаргал/-д үүрэг болгосугай.

3. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Атар өргөө” ХК /Ж.Сайнжаргал/-д үүрэг болгосугай:


1/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

2/ Хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ийг мөрдөж ажиллах;

3/ Энэхүү тогтоолын 1, 2-т заасан өөрчлөлтийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу Улсын буртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, өөрчлөлтийг тэмдэглүүлэн Хороонд ажлын 10 хоногийн дотор ирүүлэх.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай,

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН